



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/40

Хэрлэн сум

Хохирогч хамгаалах нэг цэгийн  
үйлчилгээний төвд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын наймдугаар хуралдааны "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" 2021 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.10.2 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид болон хүчирхийлэлд өртсөн хүүхдийн амь нас, эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах, түр хамгаалан байрлуулах үйлчилгээг мэргэжлийн түвшинд зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж 15 000,000 (арван таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231018186